



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДЭД

2022.03.17 № 03/654  
танай -ны № -т

Г Шинжээчээр хамтран ажиллах  
урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2018-2021 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хулээсэн үүргийн биелэлт” сэдэвт аудитад “Тавантолгойн ордын Цанхийн зүүн болон баруун, Бортээгийн хэсгийн ордын нөөц тогтоолт, олборлолтын чиглэлээр шинжээчийн дүгнэлт гаргах” зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Шинжээч нь ҮАГ-АД/22-014 дугаартай ажлын даалгаврын дагуу Монгол Улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Эрдэнэс Тавантолгой ХК болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг бүрэн хамруулж гаргах бөгөөд ажлын зорилтын хүрээнд доорх зөвлөх үйлчилгээг ажлын 44 хүртэл хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- ТЭЗҮ болон уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;
- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гэрээгээр гүйцэтгүүлж байгаа хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагааны өртгийг тооцож, дүгнэлт гаргах;
- Тухайн онуудад уулын ажлын өрнөлтөд өртсөн хөрс хуулалтын хэмжээ, хөрсний сийрэгжилтийн коэффициентын тооцооллыг хийж, дүгнэлт гаргах;
- Олборлосон нүүрс болон цаашид олборлох бүтээгдэхүүний дагалдах ашигт малтмалын судалгаа явуулсан эсэхийг судалж, ашигтай олборлоход зөвлөмж боловсруулах;
- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн өөрийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөөц тогтоолт, түүний шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийх.

Шинжээч нь ажлын даалгаварт дурдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Мэдээллээ ирүүлж буй шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, санхүүгийн дэлгэрэнгүй санал, урилгад хавсаргасан маягтаар нэмэлт мэдээллээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;

- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/;

Ажлын даалгаварт заасан зорилго, зорилтын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах шинжээчийн баг нь уул уурхай, ашигт малтмалын салбар, олон улсын чиг хандлагын талаар өргөн мэдлэгтэй, зохих мэдээллийн сан бүрдүүлсэн, макро эдийн засаг, төсөв, санхүү, бизнес, гэрээ хэлцлийн талаар зохих мэдлэгтэй, судалгаа, шинжилгээ тооцоолол, дүгнэлт гаргах чадвартай иргэн, хуулийн этгээд байж болно.

Шинжээчийн баг нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай ажилтантай байна.  
Үүнд:

- Уул уурхайн ашиглалтын инженер мэргэжилтэй, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
- Уул уурхайн салбарт 10 буюу түүнээс дээш жил ажилласан, ТЭЗҮ боловсруулах, судалгаа, шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Уул уурхайн салбарын мэргэшсэн эсвэл зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр тувшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдээллээ 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 10 минутын дотор дараах цахим хаягаар [tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn), [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)/ pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,  
Засгийн газрын IV байр, 409 тоот өрөө. Үндэсний Аудитын газар, Утас: 26 35 33.  
[www.audit.mn](http://www.audit.mn)

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

ТАВАНТОЛГОЙН ОРДЫН ЦАНХИЙН ЗҮҮН БОЛОН БАРУУН, БОРТЭЭГИЙН ХЭСГИЙН  
ОРДЫН НӨӨЦ ТОГТООЛТ, ОЛБОРЛОЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ  
ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 02 дугаар  
сарын 25.-ны өдөр

Дугаар .....

УАГ/АХ  
22-014

Улаанбаатар хот

### АЖЛЫН ЗОРИЛГО

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2018-2021 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд Тавантолгойн ордын Цанхийн зүүн болон баруун, Бортээгийн хэсгийн ордын нөөц тогтоолт, олборлолтын чиглэлээр шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Шинжээч нь аудитын талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

**Эхлэх хугацаа:** 2022 оны 03 дугаар сарын 10.-ны өдөр

**Дуусах хугацаа:** 2022 оны 08 дугаар сарын 20.-ны өдөр

**Байршил:** Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо. Жигжиджавын гудамж-8 Финанс төв, Өмнөговь аймаг Цогцэций сум, Цагаан-Овоо баг, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн салбар

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 4/233 дугаар албан бичиг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэл, , Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/53, 2021 оны A/28, 2022 оны A/12 дугаар тушаалуудаар баталсан Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2018-2021 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд аудит хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-д заасны дагуу уул уурхайн олборлолт, ашиглалтын чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад татан оролцуулах шаардлага үүссэн.

## ХОЁР АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Монгол Улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Эрдэнэс Тавантолгой ХК болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг бүрэн хамруулж дүгнэлт гаргана.

### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	ТЭЗҮ болон уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд дүгнэлт гаргах	Өмнөх аудит болон урьдчилсан судалгааны явцад ТЭЗҮ болон уулын ажлын төлөвлөгөөний дагуу уурхайн үйл ажиллагаа явуулаагүй эрсдэл тодорхойлогдсон.	Уурхайн үйл ажиллагааг зөв зохицтой, үр ашигтай ТЭЗҮ-ийн дагуу үйл ажиллагааг явуулах	<ul style="list-style-type: none"> <li>Цанхийн зүүн болон баруун, Бортзэгийн уурхайн үйл ажиллагааны батлагдсан ТЭЗҮ;</li> <li>2018-2021 оны уулын ажлын төлөвлөгөө;</li> </ul>
2	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гэрээгээр гүйцэтгүүлж байгаа хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагааны өртгийг тооцож, дүгнэлт гаргах	Эрдэнэс Тавантолгой ХК уурхайн олборлолтын өртөг тооцолтын урьдчилсан судалгааны явцад өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн.	Эрдэнэс Тавантолгой ХК уурхайн олборлолтын өртөгийг хамгийн бага байлгаж, ашгийн тувшиг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Ижил төстэй уурхайн олборлолтын өртөг, тухайлбал, Энержи Ресурс ХХК гэх мэт.</li> </ul>
4	Тухайн онуудад уулын ажлын өрнөлтөд өртсөн хөрс хуулалтын хэмжээ, хөрсний сийрэгжилтийн коэффициентын тооцооллыг хийж, дүгнэлт гаргах	2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар уурхайн хөрс хуулалтын хэмжээ болон хөрсний сийрэгжилтийн коэффициент зөрүүтэй байсан тул давтан тооцоолол хийх шаардлага тулгарсан.	Уулын ажлын өрнөлтөд өртсөн хөрс хуулалтын хэмжээ, хөрсний сийрэгжилтийн коэффициентын тооцооллыг үнэн зөв, зөрүүгүй тайлагнадаг байх	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн зөв тооцоолол</li> </ul>
5	Олборлосон нүүрс болон цаашид олборлох бүтээгдэхүүний дагалдах ашигт малтмалын судалгаа явуулсан эсэхийг судалж, үр ашигтай олборлоход чиглэсэн зөвлөмж боловсруулах	Урьдчилсан судалгааны явцад Эрдэнэс Тавантолгой ХК нь дагалдах ашигт малтмалыг ашиглахгүй байгаа нэхцэл байдал тодорхойлогдсон тул энэ талаар судалгаа хийж, зөвлөмж	Олборлосон нүүрс болон цаашид олборлох бүтээгдэхүүний дагалдах ашигт малтмалыг үр ашигтай олборлох, ордыг бүрэн ашиглах.	<ul style="list-style-type: none"> <li>Дагалдах ашигт малтмалыг ашиглах арга аргачлал</li> </ul>

		боловсруулах шаардлага тулгарсан.		
6	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн өөрийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөөц тогтоолт, түүний шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийх	Эрдэнэс Тавантолгой ХК-хайгуул хийхэд зарцуулсан хөрөнгө үр дүнтэй байгаа эсэх, нөөц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох нөхцөл үүссэн	Тавантолгойн ордын А нөөцийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Нөөц тогтоох арга аргачлал</li> </ul>
<b>Нэмэлт шаардлага:</b> Тухайн гүйцэтгэх ажил, үүргийн хүрээнд шаардлагатай тохиолдолд нэмэлт ажил гүйцэтгэх, ажил үүрэг бүрд нэмэлт ажил хийх боломжтой.				
7	Гүйцэтгэх нийт ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээ, засаж сайжруулах талаар тодорхой дүгнэлт гаргах.			

## ГЭРЭЭТ АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

- Үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зайд "single" үсгийн хэмжээ 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, ном, хэвлэл, Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын стандарт мэдээлэл зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

## ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гарган, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зерчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

## ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ажлын даалгаварт заасан зорилго, зорилтын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах шинжээчийн баг нь уул уурхай, ашигт малтмалын салбар, олон улсын чиг хандлагын талаар өргөн мэдлэгтэй, зохих мэдээллийн сан бүрдүүлсэн, макро эдийн засаг, төсөв, санхүү, бизнес, гэрээ хэлцлийн талаар зохих мэдлэгтэй, судалгаа, шинжилгээ тооцоолол, дүгнэлт гаргах чадвартай иргэн, хуулийн этгээд байж болно.

Шинжээчийн баг нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай ажилтантай байна. Үүнд:

- Уул уурхайн ашиглалтын инженер мэргэжилтэй, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
- Уул уурхайн салбарт 10 буюу түүнээс дээш жил ажилласан, ТЭЗҮ боловсруулах, судалгаа, шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Уул уурхайн салбарын мэргэшсэн эсвэл зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

### **Бүрдүүлэх материал:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дутгуйлсан байх) ;

Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

### **ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:**

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

### **ДОЛОО. БУСАД**

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана. Шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгасан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндэрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Аудитын гуравдугаар газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

### **Хянасан:**

## ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г \_\_\_\_\_ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: \_\_\_\_\_

Холбоо барих утас: \_\_\_\_\_

## ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

### 3.1. Ерөнхий танилцуулга

(Оролцогч хуулийн этгээд болон хувь хүн /баг/ нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

### 3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: \_\_\_\_\_

## САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг төвч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшил мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсарана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшил хэлний мэдлэгийн түвшинийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

МАЯГТ 5

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ<sup>1</sup>

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

МАЯГТ 6

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

МАЯГТ 7

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

<sup>1</sup> Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.